

ХААН БАНК ХХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 06 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

ХААН Банк ("Банк" гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2023 оны 06 сарын 24-ний өдөр 14:00 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-19, Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхимд (хосолсон хэлбэрээр) хуралдав.

ИРЦ

Тооллогын комиссын дарга Д.Дугарбаатар хурлын ирцийг танилцуулав.

Нийт 1,657,172,920ш энгийн хувьцаа эзэмшиж буй 229 хувьцаа эзэмшигчид хуралд бүртгүүлж оролцсон (танхимаар болон цахим) нь нийт саналын эрх бүхий 1,912,198,000ш хувьцааны 86.66 хувь болж байгааг мэдээлж Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 хэсгийг үндэслэн, нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 86.66 хувийг эзэмшигч хувьцаа эзэмшигч нар хуралд оролцож байгаа тул энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хүчин төгөлдөрт тооцогдож байгааг мэдэгдэв.

ХААН Банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын хэлэлцэх асуудал:

1. Танилцуулах асуудал:

- ХААН Банкны 2023 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга

2. Хэлэлцэн батлах эсэх асуудал:

- ХААН Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай
- ХААН Банк хувьцаат компанийн дүрмийн төслийг батлах тухай
- ХААН Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгон, томилох тухай

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дарга Т.Дарьбум (ТУЗ-ийн дарга) хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг нээж, хурлын хөтөлбөр буюу хэлэлцэх асуудлуудын талаар болон хурлын дэгийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: ХААН Банкны 2023 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга

ХААН Банкны Гүйцэтгэх Захирал Р.Мөнхтуяа ХААН Банкны 2023 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулав.

ХААН Банкны үйл ажиллагааны талаар:

Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлаас хойш Монгол Улсын эдийн засаг, ДНБ өсөлттэй байна. 2022 оны эцэст Монгол Улсын ДНБ-ий өсөлт 4.8% байсан бол 2023 онд Монгол Улсын ДНБ-ий өсөлт 4.3-5.4% байна гэж Дэлхийн Банк болон бусад олон улсын банк санхүүгийн байгууллагууд төсөөлсөн байна. 2023 оны эхний улирлын байдлаар Монгол Улсын Засгийн Газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний дүнд Монгол Улсын ДНБ-ий өсөлт 7.9%-д хүрсэн байна. ХААН Банк бизнес төлөвлөгөөндөө эдийн засагийн өсөлтийн олон хувилбаруудыг тооцсон бөгөөд хэвийн өсөлтийн төсөөлөлд Монгол Улсын ДНБ 2023 онд 4.3% өснө гэж тооцсон байна. Инфляц 2022 оны 06 сард 16%-д хүрсэн бол 2023 оны 05 сард 11.3% болж буурсан. 2023 оны эхний улиралд Монгол Улсын нийт гадаад худалдааны эргэлт 5.7 тэрбум ам.доллар, үүнээс экспорт 3.7 тэрбум ам.долларт хүрсэн. 2023 оны 1-р улирлын тоон үзүүлэлтүүд, 2-р улирлын нөхцөл байдал Монгол Улсын эдийн засаг таатай нөхцөл байдалд байгааг харуулж байна. Нөхцөл байдал энэ хэвээр цааш үргэлжилбэл 2023 онд Монгол Улсын эдийн засаг өндөр өсөлт үзүүлэх боломжтой гэж харж байна.

ХААН Банк 2021-2023 оны Дунд хугацааны бизнес төлөвлөгөөгөө ТУЗ-р батлуулан мөрдөж ажилласан. Энэ төлөвлөгөөны дагуу ХААН Банк уламжлалт банкнаас цахим банк руу шилжих шилжилтийн замд орсон. ДХБТ-д Харилцагч төвтэй бизнес, Бизнесийн эрсдэлийн удирдлага, Цахим банкны түүчээлэгч, Байгууллагын хөгжил гэсэн стратеги зорилтуудыг дэвшүүлсэн.

Энэ оны эхний улиралд хийж хэрэгжүүлсэн ажлуудаас дурдвал: ХААН Банк 2.9 сая харилцагчтай. Үүнээс 1.7 сая нь цахим банкны үйлчилгээний харилцагч байна. Манай Банкны карт эзэмшигчдийн тоо 1.9 саяд хүрсэн. ХААН Банк Монгол Улсын хүн амын 82%-д хүрч үйлчилдэг. Цаашид бид илүү өргөн хүрээтэй банкны үйлчилгээг санал болгож, банкны цахим үйлчилгээг авах давтамжийг нэмэгдүүлэх зорилт тавьж байна. Одоогоор манай цахим банкны хэрэглэгчдийн 45% нь идэвхтэй харилцагчид байгааг цаашид нэмэгдүүлэхийг зорьж байна. Бид хиймэл оюун ухаан ашиглан харилцагчдаа сегментчлэх, тэдэнд тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээг цахим сувгуудаар дамжуулан санал болгох, сурталчлах ажлыг хийж байна.

2023 оны 2 дугаар сард бид эмэгтэй харилцагч, бизнес эрхлэгч нарт чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг зах зээлд нэвтрүүлсэн. Мөн, гуравдугаар сард Монгол Улсын анхны ногоон бондыг олон улсын зах зээл дээр амжилттай гаргаж 60 сая ам.долларыг татан төвлөрүүлсэн. 2023 оны дөрөвдүгээр сард бид IPO-г амжилттай хийсэн. 2023 оны 5 дугаар сард факторингийн бизнесийг Монголд анх удаа нэвтрүүлсэн. 2023 оны 06 сарын 13-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос Монголын хөрөнгийн биржид хайбрид ногоон бонд гаргах зөвшөөрлөө авсан. Бид цаашид өөрсдийн үндсэн бизнесийг хадгалахын зэрэгцээ харилцагч нарт хэрэгцээтэй байгаа шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг үргэлжлүүлэн санал болгох болно.

ХААН Банкны нийт орлогын 84% нь хүүгийн орлого, үүнээс харилцагчийн зээлийн хүүгийн орлого 62% байна. 1-р улирлын байдлаар нийт зээлийн багц 8.4 их наяд төгрөгт хүрч оны эхнээс 6.9% өссөн. Зээлийн зардлыг бууруулах үүднээс онлайн зээлийн бүтээгдэхүүнүүдийг санал болгож байна. Нийт санхүүгийн гүйлгээний 99% нь цахимаар хийгдэж байна. 2022 онд ХААН Банкны нийт санхүүгийн гүйлгээний тоо 1,022.00 сая ширхэгт хүрсэн. 2023 оны эцэс гэхэд нийт хэрэглээний зээлийн 70%, нийт зээлийн багцын 30%-ийг онлайн зээлд шилжүүлнэ гэсэн тооцоотой байна. Онлайн зээлийн шийдвэрийг хиймэл оюун ухаан ашиглан 5-15 минутанд гаргаж байна. 1-р улирлын байдлаар нийт хэрэглээний зээлийн 37% буюу нийт зээлийн багцын 18% нь онлайн зээлд шилжсэн байна.

Технологийн шийдлүүд, харилцагчдад үйлчилгээ үзүүлдэг процессыг шинэчилсээр байна. Харилцагчид цахимаар өөрсдийгөө танин баталгаажуулах процесс хийгдсэнээр өнөөдрийн байдлаар 71,457 харилцагч өөрсдийн мэдээллийг цахимаар, 2 минутанд багтаан шинэчилсэн. 2023 онд бид 10 цахим салбар, 50 цахим булангуудыг нээхээр төлөвлөсөн. Банк өөрөө цахим/дигитал банк болж байгаатай холбогдуулан Хайбрид оффис төслийг хэрэгжүүлж байгаа. Банк төв оффист ажилтнууд зайнаас ажиллах (хайбрид оффис) дадлыг хэрэгжүүлж эхэлсэн. Нийт ажилтнуудын 70% нь оффис дээр, 30% нь гэрээсээ буюу сумын тооцооны төвөөс ажиллаж байна. Төв Банкны 1500 ажилтны 250 нь сумаас ажил үүргээ гүйцэтгэж байна.

ХААН Банк өнөөдрийн байдлаар гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас 560 сая ам.доллар буюу 1.9 их наяд төгрөгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн. Энэ эх үүсвэрийг жижиг дунд бизнес, ногоон бизнес, жендерийн мэдрэмжтэй бизнесүүдийг дэмжих зориулалтаар ашиглаж байна.

ХААН Банк нь тэргүүлэгч байгууллагын хувьд нийгмийн хариуцлагын чиглэлээр байнга анхаарал тавьж ажилладаг. ХААН Банк нь өнгөрсөн хугацаанд нийт 500 гаруй нийгмийн хариуцлагын төсөлд 9.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Өнгөрсөн жилд ХААН Банк нь МУЗГ, МҮХАҮТ-с шалгаруулдаг Монгол Улсын ТОП-100 аж ахуйн нэгжийн жагсаалтын №2-т жагссан.

Санхүүгийн гүйцэтгэл, 2023 оны 1-р улирлын байдлаар:

Нийт актив хөрөнгө 15 их наяд төгрөгт хүрсэн нь нийт банкны системийн 32.4% болсон. Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө 13.3 их наяд төгрөгт хүрсэн нь нийт банкны системийн 34.5%. Нийт зээлийн багц 8.4 их наяд төгрөг буюу нийт банкны системийн 36.8% байна. 2023 оны 03-р сарын 01-ний өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд бизнесийн зээлийн аян зарласан бөгөөд энэ хугацаанд нийт шинэ зээлийн 60-70% нь олгогддог. Энэ жил тус аяны хүрээнд 2.5 их наяд төгрөгийн зээл олгох төлөвлөгөөтэй ажиллаж байна.

2023 оны 1-р улирлын байдлаар татварын дараах цэвэр ашиг 112 сая төгрөгт хүрч санхүүгийн төлөвлөгөөг 115%-р биелүүлсэн. Өөрийн хөрөнгийн өгөөж 30%-д хүрч өссөн. Мөн, Монголбанк болон олон улсын банк санхүүгийн байгууллагуудаас тавьдаг шалгуур үзүүлэлтүүдийн харьцааг бүрэн ханган ажиллаж байна.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: ХААН Банкны Гүйцэтгэх Захирал Р.Мөнхтуяа ХААН Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоох саналыг танилцуулав.

2021 оны 01 сарын 29-ний өдөр батлагдсан Монгол Улсын Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн дагуу системийн банкууд нээлттэй хувьцаат компани болох шаардлага тавигдсан. Энэ хуулийн зохицуулалтын дагуу Монголбанк болон Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ны хамтарсан “Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ыг батласан байна.

ХААН Банкны 2022 оны 04 сарын 20-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурал №7 тоот тогтоол гарган Банкныг нээлттэй хувьцаат компани болгох шийдвэр гаргасан. Монголбанк, Монголын Хөрөнгийн Бирж (МХБ), СЗХ-ны холбогдох зөвшөөрлүүд дээр үндэслэн ХААН Банк нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,720,978,200 (нэг тэрбум долоон зуун хорин сая есөн зуун далан найман мянга хоёр зуу) ширхэг энгийн хувьцаан дээр нэмж 191,219,800 (нэг зуун ерэн нэгэн сая хоёр зуун арван есөн мянга найман зуу) ширхэг энгийн хувьцааг нэмж гаргаж, анхдагч зах зээлийн арилжааг 2023 оны 04 сарын 13-19 өдрүүдэд амжилттай хийсэн болно.

Олон нийтэд хувьцаа санал болгосны дараах байдлаар ХААН Банкны хувь эзэмшлийн бүтэц: Эйч-Эс Холдингс ХК нь 40.99%, Таван Богд Трейд ХХК нь 22.78%, Д.Хулан нь 13.22%, Эйч-Эс Интернэшнл (Ази) Лимитед компани нь 8.78%, 29,325 хувьцаа эзэмшигч анхдагч зах зээлийн арилжаанаас ХААН Банкны хувьцааг худалдан авснаар 10%-ийг эзэмшиж байгаа бол ХААН Банкны 4136 ажилтнууд 4.23%-ийг эзэмшиж байна.

Иймд дээрх хүрээнд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ХААН Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг 191,219,800,000.00 төгрөгөөр тогтоож, ХААН Банкны Дүрэмд энэ дүнг тусгах саналыг танилцуулж байна.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: ХААН Банк ХК-ийн дүрмийн төслийн танилцуулга

ХААН Банкны ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга О.Ариунтулга, ХаанЛекс Партнерс ХХН-ийн Гүйцэтгэх Захирал И.Учралбаяр нар ХААН Банк ХК-ийн дүрмийн төслийг танилцуулав.

О.Ариунтулга: ХААН Банк ХК-ийн Дүрмийн төслийг ХААН Банкны Хууль эрх зүйн газар боловсруулж, хөндлөнгийн хуулийн фирм болох өмгөөллийн Хаан Лекс Партнерс ХХН холбогдох хууль тогтоомжийн нийцлийг хянаж, хөндлөнгийн хуулийн дүгнэлт гаргасан. Дүрмийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын Иргэний Хууль, Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, зохицуулагч байгууллагуудын дүрэм журамд үндэслэн, нийцүүлж боловсруулсан. Дүрмийн ерөнхий бүтцэд:

1. Банкны үйл ажиллагаа, хувь нийлүүлсэн хөрөнгө,
2. Хувьцаа эзэмшигчдийн хурал, эрх үүрэг,
3. Төлөөлөн удирдах зөвлөл, эрх үүрэг,
4. Банкны эрх бүхий албан тушаалтан,
5. Хэлцэл, тайлан
6. Бусад гэсэн сэдвүүдийг хамарсан нийт 20 зүйл орсон, ХААН Банкны эрх зүйн байдал, үйл ажиллагааг бүхэлд нь хамарсан томоохон эрх зүйн акт болсон тухай ерөнхий мэдээллийг өгөв.

И.Учралбаяр: Өмгөөллийн Хаан Лекс ХХН нь ХААН Банкны IPO-той холбогдуулан хуулийн дүгнэлт гаргаж ажилласан. Энэ хүрээнд ХААН Банк ХК-ийн дүрмийн төслийг хянасан. Энэ хүрээнд тус дүрэмд тусгагдсан онцлох зохицуулалтуудаас дурдвал:

Хувьцаа эзэмшигчдийн эрх үүрэг /Дүрмийн 6-р зүйл/:

Банкны тухай хууль болон Компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигчдийн нийтлэг эрхүүд, үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох
- Санал өгөх
- Хувьцааг эргүүлэн худалдан авахыг шаардах
- Ногдол ашиг хүртэх
- Жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан мэдээлэлтэй танилцах эрхүүд орсон.

Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь Монголбанкны холбогдох журмаар тогтоосон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн тодорхойлолтод өөрчлөлт орох тухай бүрт Банканд мэдэгдэх үүрэгтэй.

Хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний бүрэн эрх /Дүрмийн 7-р зүйл/:

- Банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Компанийн тухай хуулийн 62.1-т зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Тухайлбал:
 - Банкны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах буюу Банкны дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах (Дүрмийн 7.2.1.)
 - ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох (Дүрмийн 7.2.7)
 - Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг өөрчлөх (Дүрмийн 7.2.15)
 - Банкны тухайн жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар ТУЗ-өөс бэлтгэсэн тайланг хэлэлцэж, батлах (Дүрмийн 7.2.14)
 - ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал (Дүрмийн 7.2.16)

Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус гэсэн 2 төрөлтэй. Ээлжит хурал нь тухайн санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор хуралдах ёстой бол ээлжит бус хурлыг Банкны хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүний саналаар зарлан хуралдуулна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц дийлэнх олонх буюу 66.6%-иар бүрдэхээр заасан. Компанийн тухай хуульд хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц 51% байж болох боловч үүнийг компанийн дүрмээр нэмэгдүүлж тогтоож болно гэж заасан. Ирцийг нэмэгдүүлж 66.6% болгож тогтоосноор жижиг хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангах боломжийг нээж өгөх давуу талтай.

Санал хүчин төгөлдөр болох хувь хэмжээг Компанийн тухай хуульд зарим асуудал дээр 51%, зарим асуудал дээр 66.6% байхаар заасан. Дүрмээр энэ хувийг мөн нэмэгдүүлж болно. ХААН Банк ХК-ийн Дүрмийн төсөлд санал хүчин төгөлдөр болох хувь хэмжээг 66.6% байхаар тусгасан байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн эрх, үүрэг (Дүрмийн 9-р зүйл):

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Банкны эрх барих байгууллага нь ТУЗ байна.

ТУЗ нь есөн (9) гишүүнээс бүрдэнэ. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд хүйсийн харьцаа гучин (30) хувиас багагүй байхаар жендерийн тэнцвэртэй байдлыг хадгалахыг эрмэлзэнэ. Хамгийн багадаа гурав (3)-ны нэгээс доошгүй хувь нь ТУЗ-д хараат бус гишүүн байна (Дүрмийн 9.1).

ТУЗ-ийн дарга нь хараат бус гишүүдээс томилогдоно (Дүрмийн 9.19) гэж заасан нь маш зоригтой шийдэл болсон байна. Ингэснээр ТУЗ-ийн хурал илүү нээлттэй болж, олон ургальч үзлийг дэмжихээс гадна ТУЗ-ийн хараат бус гишүүдийн идэвх оролцоо сайжрах ач холбогдолтой. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрх 3 хүртэлх жил байна. ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар улируулан сонгож болно (Дүрмийн 9.7).

ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76.1, Банкны тухай хуулийн 31.3 болон Монголбанк, СЗХ, МХБ-ийн холбогдох журам, дүрэмд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ (Дүрмийн 9.13) гэж заасан байна.

Гүйцэтгэх удирдлага:

Банкны гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-с томилогдсон гүйцэтгэх захирал дангаар хэрэгжүүлнэ (Дүрмийн 13.1).

Гүйцэтгэх удирдлага нь:

- Банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хяналт тавина.
- Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн гаргасан бүх шийдвэр, тогтоолын зохих хэрэгжилтийг хангана.
- ТУЗ-тэй байгуулсан гэрээний нөхцөл болзлын дагуу ажил үүргээ хэрэгжүүлнэ (Дүрмийн 13.2).

ТУЗ нь гүйцэтгэх захирлыг Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцөн, санал солилцсоны үндсэн дээр томилно.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: ХААН Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгон, томилох тухай

ТУЗ-ийн дэд дарга Д.Хулан ХААН Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгон, томилох саналыг танилцуулав.

ТУЗ-ийн хараат бус гишүүдийг Монголбанкны “Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-ын дагуу Банкны ТУЗ-ийн дэргэд ТУЗ-ийн хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх түр хороо 2023 оны 05 сарын 14-ний өдөр байгуулсан. Мөн журмын дагуу 2023 оны 05 сарын 18-23-ны өдрүүдэд олон нийтийн дунд сонгон шалгаруулалт зохион байгуулж хууль, журмын шаардлагыг хамгийн сайн хангасан нэр дэвшигчдийг шалгаруулж өнөөдрийн хуралд 3 нэр дэвшигчийг танилцуулж байна. ХААН Банкны Дүрэмд заасанчлан, ТУЗ-д 3-с багагүй хараат бус гишүүн ажиллах ёстой.

1. Хараат бус гишүүнд нэр дэвшигч Түдэв овогтой Дарьбум:

Боловсрол:

- 1985-1990 Москва хотын Санхүүгийн дээд сургууль
- 1995-1997 АНУ-ын Сиатлын их сургууль
- Канад улсын Онтариогийн мэргэшсэн нягтлан бодогчийн их сургууль – СРА (мэргэшсэн нягтлан бодогч), СМА (мэргэшсэн менежментийн нягтлан бодогч) зэрэгтэй

Ажлын туршлага:

- 2020 оноос ХААН Банк – ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дарга
- 2018-2020 Торонто Доминион Банк групп (Торонто, Онтарио) – Санхүүгийн Засаглал, Эрсдэл, Хөрөнгө болон Балансын удирдлагын Ахлах шинжээч
- 2016-2018 Торонто Доминион Банк групп (Торонто, Онтарио) – Байгууллагын үйл ажиллагааны Эрсдэлийн удирдлагын Ахлах эрсдэлийн шинжээч
- 2010-2016 Торонто Доминион Банк групп (Торонто, Онтарио) – Активын удирдлага, хөрөнгө оруулалтын удирдлагын Зөвлөх
- 2007-2010 Торонто Доминион Банк групп (Торонто, Онтарио) – Баялгийн удирдлагын Ахлах сангийн нягтлан бодогч
- 2006-2007 Грөүт Воркс капитал – Үнэт цаасны нягтлан бодогч
- 2004-2006 Макуаир групп (Филадельф, Пенсилваниа) – Харилцан сангийн нягтлан бодогч
- 2004 Би Эн Уай Мэллон (Вэлмингтон, Делавэр) – Хөрөнгө оруулалтын нягтлан бодогч
- 1992-2002 Алтай Холдингс групп – Гадаад худалдаа хариуцсан захирал, Санхүү хариуцсан захирал, Партнер

2. Хараат бус гишүүнд нэр дэвшигч Ханс Аарт Йонгеяанс:

Боловсрол:

1. 1973-1974 Нидерландын банк, санхүүгийн институт (NIBE), Банкны эрсдэл судлал

Ажлын туршлага:

1. 2020 оноос ХААН Банк – ТУЗ-ийн хараат бус гишүүн
2. 2016-2017 Голомт Банк – Гүйцэтгэх захирлын Эрсдэлийн удирдлага хариуцсан зөвлөх
3. 2013-2016 Хас Банк – Эрсдэл хариуцсан дэд захирал
4. 2010-2013 Би-Эн-Пи Парибас – Бүс нутаг хариуцсан зээлийн менежер
5. 2004-2009 Саудын Холланди Банк – Эрсдэл хариуцсан дэд захирал
6. 1998-2003 Азийн банк – Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч ба Эрсдэлийн удирдлагын газрын дарга
7. 1988-1998 Эй-Би-Эн АМРО – Төслийн менежерийн орлогч;
 - а. Эрсдэл удирдлагын мэдээллийн менежер;
 - б. Зүүн өмнөд Азийн бүсийн эрсдэлийн удирдлагын дэд захирал;
 - с. Зээлийн шинжилгээ хариуцсан захирал;
 - д. Эрсдэлийн удирдлагын газрын даргын орлогч
8. 1981-1988 Эй-Би-Эн Банк төв оффисын дотоод зээлийн хэлтэс
9. 1978-1981 Токай Банк Нидерланд синдикатын хэлтэс

3. Хараат бус гишүүнд нэр дэвшигч Амарбаясгалангийн Тамир:

Боловсрол:

1. 1991-1994 Санхүү эдийн засгийн дээд сургууль
2. 1997-1998 Австралийн Үндэсний их сургууль
3. 2005-2008 Москва хотын Эдийн засаг, статистик, информатикийн их сургууль

Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт – Мэргэшсэн нягтлан бодогч, Татварын мэргэшсэн зөвлөх

Ажлын туршлага:

1. 2020 оноос ХААН Банк – ТУЗ-ийн хараат бус гишүүн
2. 2008 оноос Пи Кэй Эй Эй Эс Монголиа – Ерөнхий захирал, үүсгэн байгуулагч
3. 2021 оноос Ази номхон далайн бүсийн татварын зөвлөхүүдийн нийгэмлэг – Дэд ерөнхийлөгч
4. 2013 оноос Дэлхийн татварын зөвлөхүүдийн платформын хорооны гишүүн
5. 2006-2008 ОХУ-ын Газпром банкны Монгол дахь суурин төлөөлөгч – Дэд захирал
6. 2003-2006 Үйлдвэр худалдааны яам – Үйлдвэрийн бодлого, зохицуулалтын газрын орлогч дарга
7. 1994-2003 Үндэсний татварын ерөнхий газар – Татварын бодлого зохицуулалтын хэлтсийн ахлах байцаагч

Компанийн тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийг нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нэр дэвшүүлэх эрхтэй. Эдгээр нэр дэвшигчдийг ТУЗ-ийн дэргэдэх Компанийн Засаглалын Хороонд танилцуулдаг. Тус Хороо нь өөрийн дүрэмд заасан чиг үүргийн дагуу хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн материал хууль журамд заасан шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг шалгаж, хэд хэдэн удаа хуралдсаны эцэст эдгээр нэр дэвшигчдийн материалыг Монголбанканд хүргүүлсэн ба хувьцаа эзэмшигчдийн хуралд үүгээр толилуулж байна.

1. Ердийн гишүүнд нэр дэвшигч Харада Ясүнари (Эйч-Эс Интернэшнл (Ази) Лимитед компанийн төлөөлөл):

Боловсрол:

1. 1988-1992 Япон улсын Кюүшюүгийн их сургууль

Ажлын туршлага:

- a. 2022 оноос ХААН Банк – ТУЗ-ийн гишүүн
- b. 2021 оноос Эйч Эс Холдингс ХК – Төлөөлөгч захирал, Ерөнхийлөгч
- c. 2021 Жапан кикан капитал инк – Жапан кикан капитал инк – Бизнес хөгжлийн түнш, Зөвлөх
- d. 2013-2021 Сошиэт женерале секьюритис ХК, Токио дахь салбар – Санхүүгийн байгууллагын газрын Ерөнхий менежер / Удирдах захирал
- e. 2008-2013 Ренэйссенс капитал групп инк (Би-Эн-Пи Парибас секьюритис (Жапан) лимитед компанийн охин компани) – Ерөнхий менежер

2. Ердийн гишүүнд нэр дэвшигч Цагаачийн Баатарсайхан (Таван Богд Трейд ХХК-ийн төлөөлөл):

Боловсрол:

1. 1984-1988 Монгол Улсын Политехникийн их сургууль

2. 1988-1989 Япон Улсын Токиогийн гадаад хэл судлалын сургууль
3. 1989-1993 Япон Улсын Токио хотын Цахилгаан холбоо, Электроникийн их сургууль

Ажлын туршлага:

1. 2009 оноос ХААН Банк – ТУЗ-ийн гишүүн
 2. 2007 оноос Говь ХК – ТУЗ-ийн гишүүн
 3. 2008 оноос Говь ХК – Гүйцэтгэх захирал
 4. 2001-2003 МИАТ компани – Дэд захирал
 5. 1997 оноос Таван Богд Групп – Ерөнхий захирал, Ерөнхийлөгч
 6. 1993-1997 Япон Монголын хамтарсан Алтай компани – Орлогч захирал
3. Ердийн гишүүнд нэр дэвшигч Иший Кисабүро (Эйч-Эс Холдингс ХК-ийн төлөөлөл):

Боловсрол:

1. 1974-1979 Япон Улсын Токиогийн их сургууль

Ажлын туршлага:

1. 2022 оноос ХААН Банк – ТУЗ-ийн гишүүн
 2. 2022 оноос Эйч Эс Холдингс ХК – ТУЗ-ийн хараат бус гишүүн
 3. 2019 оноос Дугуйн зогсоолын төхөөрөмжийн сан – Ерөнхийлөгч
 4. 2015-2018 Япон Улсаас Румын Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд
 5. 2019 Япон Улсын Мицүи Сүмитомо далайн даатгал – Зөвлөх
 6. 2014-2015 Газар, дэд бүтэц, тээврийн яам – Дэд сайд
 7. 2013-2014 Газар, дэд бүтэц, тээврийн яам – Хотын товчооны ерөнхий захирал
 8. 2011-2013 Япон улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Номхон далайн түншлэлийн төв штаб – Засгийн газрын хэрэг эрхлэх газрын зөвлөх
 9. 2009-2011 Хотын сэргэн мандалтын агентлаг – Дэд ерөнхийлөгч
 10. 2007-2009 Токиогийн их сургууль – Зочин профессор
 11. 1998-2000 Санхүүгийн сэргээн босголтын комисс – Тамгын газрын хэрэг эрхлэх албаны төлөвлөлтийн ажилтан
4. Ердийн гишүүнд нэр дэвшигч Дашдаваагийн Хулан (Бие даасан хувьцаа эзэмшигч):

Боловсрол:

1. 1985-1990 Москвагийн Санхүүгийн Их Сургууль

Ажлын туршлага:

1. 2003 оноос ХААН Банк – ТУЗ-ийн гишүүн
2. 2002 оноос Таван Богд Групп – Тэргүүн дэд ерөнхийлөгч, ТУЗ-ийн дарга
3. 2009 оноос Монгол улс дахь Люксембургийн Вант Улсын Өргөмжит Консул
4. 2008 оноос Говь ХК – ТУЗ-ийн гишүүн
5. 2022 оноос Таван Богд Фүүдс Пицца ХХК – ТУЗ-ийн дарга
6. 2022 оноос Таван Богд Фүүдс ХХК – ТУЗ-ийн дарга
7. 2014-2022 Таван Богд Фүүдс Пицца ХХК – Гүйцэтгэх захирал
8. 2013-2022 Таван Богд Фүүдс ХХК – Гүйцэтгэх захирал
9. 2002-2003 Хөдөө аж ахуйн банкны хувьчлалын тендерийн Эйч Эс Сэжуритис ХК-ийн зөвлөх, төлөөлөгч
10. 2000-2002 Кредит Монгол Зээлийн хорооны гишүүн
11. 2000-2002 Худалдаа хөгжлийн банк – Дэд захирал

12. 1993-1997 Япон улсын Токио хот дахь “Говь” компанийн төлөөлөгч байгууллага – Худалдааны менежер
13. 1990-1992 Сангийн яам – Эдийн засагч
5. Ердийн гишүүнд нэр дэвшигч Жон Ло (Эйч-Эс Холдингс ХК-ийн төлөөлөл):

Боловсрол:

1. 1974 Тайванийн Чанг Юан их сургууль
2. 1979 Франц улсын Парисийн их сургууль
3. 1982 АНУ-ын Индианагийн их сургууль

Ажлын туршлага:

1. 2016 оноос ХААН Банк – ТУЗ-ийн гишүүн
2. 2013-2020 Оливер Вайман – Ахлах зөвлөх
3. 2004-2012 Дэлхийн Банк / ОУВС Глобал санхүүгийн зах зээл – Банкны ерөнхий мэргэжилтэн
4. 2000-2003 Ситибанк/Ситигрупп – Ази номхон далайн санхүүгийн зах зээлийн Бүс хариуцсан зээлийн эдийн засагч
5. 1999-2000 Жей Пи Морган & Компани – Евроклейрингийн Ази, номхон далайн бүсийн Зээлийн ахлах эдийн засагч
6. 1997-1999 Жей Пи Морган & Компани – Хятад дахь Эрсдэлийн менежер
7. 1995-1997 Жей Пи Морган & Компани – Ази, номхон далайн бүс дэх Сургалт хариусан захирал
8. 1993-1995 Ситибанк / Ситикорп – Хойд Хятад дахь Бизнесийн менежер
9. 1991-1993 Ситибанк / Ситикорп – Ази номхон далайн бүсийн Бизнесийн эрсдэлийн хянагч
10. 1989-1990 Ситибанк / Ситикорп – Хойд Америкийн хөшүүрэгт Баруун капиталын хэлтэст эрхлэгч
11. 1986-1989 Ситибанк / Ситикорп – Ази номхон далайн банкны институтэд Хөтөлбөрийн менежер
12. 1982-1986 Ситибанк Тайпэй салбар - Дансны мэргэжилтэн
6. Ердийн гишүүнд нэр дэвшигч Батболдын Амарсанаа (Таван Богд Трейд ХХК-ийн төлөөлөл):

Боловсрол:

1. 1995-1999 Монгол Улсын их сургууль, Хууль зүйн сургууль
2. 2000-2002 Нагояагийн их сургууль
3. 2005-2008 Нагояагийн их сургууль

Ажлын туршлага:

1. 2022 оноос ХААН Банк – ТУЗ-ийн гишүүн
2. 2021 оноос Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургуулийн захирал
3. 2012 оноос МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын олон улсын арбитр – Арбитрч
4. 2014 оноос Хууль зүйн ухаанаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүн
5. 1999-2021 Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургууль – цагийн багш, багш, профессор, дэд профессор, тэнхимийн эрхлэгч
6. 2013-2022 Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хороо – Хяналтын зөвлөлийн гишүүн
7. 2020-2022 Эрдэнэс Монгол ХХК – ТУЗ-ийн хараат бус гишүүн
8. 2013-2020 Монгол Улсын Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн дэргэдэх Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүн
9. 2013 оноос Монголын Хуульчдын Холбооны чиг үүргийн хороо Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хорооны дарга, гишүүн
10. 2015-2016 Монгол Улсын Засгийн Газрын гишүүн, Уул уурхайн яамны сайдын хуулийн орон тооны бус зөвлөх

11. 2014-2015 Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн философи, социологи, эрх зүйн хүрээлэн, эрдмийн зөвлөлийн гишүүн
12. 2012-2014 Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн – Дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга
13. 2011-2016 Хууль Зүйн Үндэсний Хүрээлэнгийн Хууль дээдлэх ёс сэтгүүл – Эрхлэгч, Редакцын зөвлөлийн гишүүн
14. 2004-2010 АНУ-ын Вашингтоны их сургуулийн Хуулийн сургууль, Тайванийн Үндэсний их сургуулийн Хууль зүйн сургууль, Япон Улсын Нагоягийн их сургууль – Зочин судлаач, гадаад судлаач

ХААН Банкны ТУЗ-д нэр дэвшиж буй нийт 9 нэр дэвшигчдийн талаарх танилцуулгыг хийж дуусгав.

Хурлын дарга хурлын хөтөлбөрийн дагуу дараагийн хэсэг болох тус хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал хураахтай холбогдуулан Тооллогын Комиссын дарга Д.Дугарбаатар дэлгэрэнгүй тайлбар өгөхийг урьж, Тооллогын комиссын дарга санал өгөх зааварчилгааг нийт хувьцаа эзэмшигчдэд тайлбарлав.

Хурлын дарга Т.Дарьбум өнөөдрийн хурлын танилцуулга, хэлэлцүүлэх асуудлын хэсэг өндөрлөж, асуулт хариултын хэсэгт шилжсэнийг мэдэгдэв.

Асуулт, хариулт:

Асуулт №1 (цахимаар оролцож буй хувьцаа эзэмшигчдээс асуулт асуув):

- Ногдол ашиг хэзээ тараах вэ?

Хариулт (ХААН Банкны гүйцэтгэх захирал Р.Мөнхтуяа):

- ХААН Банк нь Ногдол ашгийн бодлоготой. Уг бодлогод тухайн жилийн цэвэр ашгийн 40-60%-ийг ногдол ашиг хэлбэрээр тараана гэж заасан. Компанийн тухай хуулийн дагуу тайлант хугацаа дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх, ямар хэмжээгээр хуваарилах тухай шийдвэр гаргана. Иймд, 2023 оны 12 сарын 31-ний өдрөөс 2024 оны 02 сарын 19-ний өдрийн дотор 2023 оны татварын дараах цэвэр ашгийн 40-60 хувийг ногдол ашиг хэлбэрээр тараах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх юм.

Асуулт №2 (цахимаар оролцож буй хувьцаа эзэмшигчдээс асуулт асуув):

- Дараагийн дунд хугацааны стратеги хэзээ батлагдах вэ?

Хариулт (ХААН Банкны гүйцэтгэх захирал Р.Мөнхтуяа):

- 2021-2023 оны Дунд хугацааны төлөвлөгөөг 2021 оны 1-р улиралд ХААН Банкны ТУЗ-р батласан. Бид 2024-2026 оны бизнес төлөвлөгөөг 2023 оны 4-р улиралд ТУЗ-д санал болгож танилцуулж хэлэлцсэний үндсэн дээр 2024 оны 1-р улиралд багтаан батлахаар төлөвлөн ажиллаж байна.

Хурлын дарга Т.Дарьбум асуулт асуусан хувьцаа эзэмшигч нарт баярлсанаа илэрхийлж хувьцаа эзэмшигчдэд асууж, тодруулах зүйл байвал ХААН Банкны ТУЗ-ийн ажлын албанд хэзээд хандаж болохыг хэлэв.

Үргэлжлүүлэн хурлын дарга тус хурлын хөтөлбөрийн дагуу энэхүү хурлаар хэлэлцсэн 3 асуудлын санал хураалтыг эхлүүлэв.

Санал хураалт:

1. ХААН Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 191,219,800,000.00 төгрөгөөр тогтоох эсэх,
2. ХААН Банк хувьцаат компанийн дүрмийн төслийг батлах тухай эсэх,
3. ХААН Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгон, томилох тухай (кумулятив санал хураалт)

Хурлын хөтөлбөрийн дагуу 15 минутын завсарлага авав. Завсарлага дуусаж хувьцаа эзэмшигчид хурлын танхимд цугласны дараагаар хурлын дарга Т.Дарьбум санал хураалтыг дуусгаж Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэн танилцуулахыг хүсэв.

Тооллогын Комиссын дарга Д.Дугарбаатар нийт санал хураасан 3 асуудал хэрхэн болон хэдэн хувиар батлагдсаныг нарийвчлан танилцуулав.

1-р шийдвэрлэх асуудал: ХААН Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 191,219,800,000.00 (нэг зуун ерэн нэгэн тэрбум хоёр зуун арван есөн сая найман зуун мянган) төгрөг байх саналд санал хураалтад оролцсон хувьцаа эзэмшигчдийн 99.83 хувь буюу 1,654,436,378 ширхэг хувьцаатай 145 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар санал өгсөн байна. Саналыг нэгтгэхэд, хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.999% зөвшөөрсөн, 0.0001% татгалзсан, 0.001% түдгэлзсэн байна.

2-р шийдвэрлэх асуудал: ХААН Банк Хувьцаат Компанийн Дүрмийг батлах саналд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.83% буюу 1,654,436,378 ширхэг хувьцаатай 145 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Саналыг нэгтгэхэд, хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.99537% зөвшөөрсөн, 0.00009% татгалзсан, 0.00454% түдгэлзсэн байна.

3-р шийдвэрлэх асуудал: ХААН Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох саналд кумулятив аргаар санал хураасан бөгөөд ХААН Банкны ТУЗ-ийн гишүүдийг сонгох, томилох тухай санал хураалтад хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.83% буюу 1,654,436,378 ширхэг хувьцаатай 145 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Саналыг кумулятив аргаар тоолж нэгтгэхэд

Ердийн гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Ноён Цагаач овогтой Баатарсайхан	1,846,970,788
2	Хатагтай Дашдаваа овогтой Хулан	1,850,042,786
3	Ноён Харада Ясүнари	1,268,634,215
4	Ноён Иший Кисабүро	1,265,735,241
5	Ноён Батболд овогтой Амарсанаа	1,859,871,427
6	Ноён Жон Ло	1,843,762,957
	Нийт	9,935,017,414

Хараат бус гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Хатагтай Түдэв овогтой Дарьбум	1,652,852,067
2	Ноён Ханс Аарт Йонгеянс	1,651,448,059
3	Ноён Амарбаясгалан овогтой Тамир	1,650,609,732
	Нийт	4,954,909,858

Хурлын дарга Т.Дарьбум санал хураалтад оролцсон хувьцаа эзэмшигч нарт талархсанаа илэрхийлээд хурлаас гаргасан шийдвэрүүдийг уншиж танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: ХААН Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 191,219,800,000.00 (нэг зуун ерэн нэгэн тэрбум хоёр зуун арван есөн сая найман зуун мянган) төгрөг байхаар тогтоов.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: ХААН Банк Хувьцаат Компанийн Дүрмийг шинэчлэн батлав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: ХААН Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлд 6 ердийн гишүүн, 3 хараат бус гишүүнийг сонгов.

Хурлын дарга Т.Дарьбум ХААН Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхдугаар хурал хаасныг мэдэгдэв. ХААН Банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдэд талархсанаа илэрхийлж дараагийн хурлаар дахин уулзахыг хүсэв.

Хэлэлцэх асуудал үүгээр дууссан тул 2023 оны 06 сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 16:30 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлийг хөтөлсөн:



О.Ариунтулга

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

Хурлын дарга



Т. Дарьбум

ТУЗ-ийн дарга